



**ХЭНТИЙ АЙМАГ  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР**

2022 оны 08 сарын 18 өдөр

Дугаар 01

Бор-Өндөр сум

**2022-2023 оны Өвөлжилт хаваржилтийн  
бэлтгэл хангах тухай**

Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг байгалийн болзошгүй гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлыг төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, малчид, иргэдийн түвшинд сайтар зохион байгуулж хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор Засгийн газрын 2022 оны “Хөдөө аж ахуйн 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” 277 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2022 оны “2022-2023 оны өвөлжилт хаваржилтын болон ургац хураалтын бэлтгэл хангах тухай” 09 дүгээр албан даалгавар, Аймгийн Засаг даргын “2022-2023 оны Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилт болон ургац хураалтын бэлтгэл хангах тухай” 2022 оны 05 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

**1. Хөдөө аж ахуйн тасаг, Хүйх, Өлгий багийн Засаг дарга нарт даалгах нь:**

**1.1. Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах чиглэлээр:**

1.1.1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 20-ны 277 дугаар тогтоолын дагуу сумын аюулгүйн нөөцөд 80 тн өвс, 40 тн тэжээл бэлтгэж 10 дугаар сарын 01-ний дотор өвс, тэжээлийн хадгалах агуулахад төвлөрүүлэх.

1.1.2. Хадлан бэлтгэж буй сумдын аж ахуйн нэгж байгууллагуудтай харилцан тохиролцож өвс худалдан авах гэрээ, хэлцлийг хийх ажлыг зохион байгуулах.

1.1.3. Мал сүрэгт намрын үзлэг, ангилалт, заазлалт, ээмэгжүүлэлт бүртгэлжүүлэлтийн ажлыг мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжтэй хамтран зохион байгуулах.

1.1.4. Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироонд судалгаа хийж тохироогоор дутагдаж буй хээлтүүлэгчийг нөхөн бойжуулах, худалдан авах, хээлтэгч малыг биотехнологийн дэвшилтэд арга ашиглан зохиомлоор хээлтүүлэх ажлыг орон нутагт нэвтрүүлэх.

1.1.5. Малын тэжээл үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж, сумын аюулгүйн нөөц бүрдүүлэхээс гадна малчдад малын тэжээл худалдан борлуулах ажлын уялдааг сайжруулах.



1.1.6. Хүнсний ногоо, ургамлын иш, навч, болон таана, хөмүүл, халгай, лууль зэрэг ургамлыг даршлах, гар тэжээл бэлтгэх арга, технологийг малчдад зааж сурган бэлтгүүлэх ажлыг зохион байгуулах.

1.1.7. Эр сувай малыг эдийн засгийн эргэлтэнд оруулах, төв суурингийн хүнсний хангамжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

1.1.8. Бэлтгэсэн мах, дайвар бүтээгдэхүүнийг түр хугацаанд хадгалах, эрүүл ахуйн шаардлага хангасан агуулах бэлтгэх, төв суурин газрын махны үйлдвэр, худалдаа үйлчилгээний төв, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан борлуулах, тээвэрлэх ажлыг зохион байгуулах.

1.1.9. Бэлтгэсэн малын арьс, ширэнд анхан шатны боловсруулалт хийх, мэргэжлийн холбоодтой хамтран худалдан борлуулах ажлыг зохион байгуулах.

1.1.10. Бор-Өндөр сумын төвийн хүн амын өвөл, хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх.

1.1.11. Цаг агаарын улирлын урьдчилсан төлөв байдлын мэдээ, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн богино, дунд хугацааны урьдчилсан мэдээг малчид, иргэдэд шуурхай хүргэх, урьдчилсан сэргийлэх арга хэмжээг тогтмол авах.

1.1.12. Малчин өрх бүрийн худаг, уст цэг, өвөлжөө, хашаа, хорооны хүрэлцээ хангамжийн тооцоог баг, малчин өрх бүрээр гаргах, малын хашаа хороог засварлах, цаг агаар хүндэрсэн үед хэрэглэх тоног хэрэгсэл, дулаан хувцас, хоол хүнс, түлээ, нүүрс, өтөг бууц зэрэг өрхийн өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангуулах ажлыг зохион байгуулах.

1.1.13. Мал сүргийг ээмэгжүүлж, бүртгэлжүүлэх, өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх, тэжээлийн агуулах, саравч барих зэрэг ХАА-н холбогдолтой ажил үйлчилгээг малын тоо толгойн албан татварын болон арьс, шир, ноосны урамшууллын 10 хувийн хөрөнгөөр санхүүжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах.

1.1.14. Малын тоо, толгойн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, орлого бүрдүүлэлтэд Татварын тасагтай хамтран ажиллах.

1.1.15. 2022-2023 оны Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, хадлан тэжээл бэлтгэлийн мэдээг 7 хоног бүрийн лхагва гарагт, мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангасан дүнг загвар хүснэгтийн дагуу гаргаж 10 дугаар сарын 01-ний дотор аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлэх.

## 2. Мал эмнэлгийн тасагт даалгах нь:

2.1. Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулж, мал эмнэлгийн дуудлага үйлчилгээний бэлэн байдлыг бүрдүүлж, шуурхай удирдлагаар хангах.

2.2. Мал сүрэгт намрын угаалга, туулгалт, дархлаажуулалт зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөгөөт хугацаанд чанартай зохион байгуулж, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр хүртээмжтэй хангах.

2.3. Мал сүргийн хамуу, хүрд, ширх, гуур зэрэг эктопаразитаас хамгаалах арга хэмжээг 10 дугаар сарын 01-ний дотор бүрэн хэрэгжүүлж, өвөлжөө, хаваржаанд нь паразитын устгал, ариутгал хийх арга хэмжээг зохион байгуулах.



2.4. Малын шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хянах, хязгаарлахтай холбоотой зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

2.5. Мал эмнэлгийн бэлэн байдлын нөөцөд үнэлгээ хийж, нөөцийг нөхөн бүрдүүлэх.

3. Онцгой байдлын хэлтэст даалгах нь:

3.1. Сумын өвөлжилт, хаваржилтийн нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээл, тусламжийн бараа авахад хүн хүч, техникийн дэмжлэг үзүүлэх, сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдалд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангах.

4. Бор-Өндөр цогцолбор сургуульд даалгах нь:

4.1. Намрын төмс, хүнсний ногоо хураалтад сурагчдыг идэвхтэй татан оролцуулах зорилгоор ахлах ангийн сургалтын хөтөлбөрт хөдөлмөрийн дадал, ур чадвар олгох хэлбэрээр хичээлийн агуулгыг татан оруулах боломжийг халамжийн мэргэжилтнээр дамжуулан Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран судалж, танилцуулах.

5. Санхүүгийн албанд даалгах нь:

5.1. Өвөл, хаврын ган, зудын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хохирол багатай даван туулах зорилгоор Засгийн газрын 2022 оны 07 дугаар сарын 20-ний 277 дугаар тогтоолын дагуу сумын аюулгүйн нөөцөд 80 тн өвс, 40 тн тэжээл бэлтгэж, татан авч нөөцлөх.

6. Бор-Өндөр Уулын баяжуулах үйлдвэрт даалгах нь:

6.1. Сумын төвийн дулаан, цэвэр усны усан хангамжийн найдвартай байдлыг хангах зорилгоор шугам сүлжээ, насос, мотор, үлээгчийн засвар үйлчилгээ тохируулгыг бүрэн хийж, өвлийн улиралд найдвартай ажиллах бэлтгэлийг хангах,

6.2. Халаалтын улиралд гаднах агаарын температураас хамааралтайгаар хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр тасралтгүй хангаж, батлагдсан температурын графикийн дагуу, технологийн горимыг барьж ажиллах,

6.3. Дулааны цэвэр усны хангамжийн саатал, ослын үед ажиллах багийг бэлэн байдалд байлгаж, ажилчдыг чадавхижуулах, гэмтэл саатлыг арилгах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг тогтмол шуурхай мэдээлж байх,

7. Албан байгууллагын дарга эрхлэгч нарт даалгах нь:

7.1. Дулаан хэрэглэгч байгууллагууд /төсвийн/ өөрсдийн эзэмшлийн шугам, сүлжээнд урсгал засвар хийх, дулаан хүлээн авах бэлтгэлийг сайтар хангах, албан байгууллагын дарга нар батлагдсан төсөвт багтаан төлбөрийн асуудлыг шийдвэрлэх.

7.2. Албан байгууллагууд өөрсдийн эзэмшлийн байшин барилгын цонх, хаалга, ханын дулаан алдагдлыг арилгах талаар арга хэмжээг 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор авч ажиллах.

8.Засаг даргын Тамгын газарт даалгах нь:

8.1.Албан даалгаврыг хэрэгжүүлэхэд удирдлага зохион байгуулалтаар хангах, гүйцэтгэлийг зохион байгуулах, үр дүнг 2022 оны 10 дугаар сарын 10-ны дотор танилцуулж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасгийн дарга (П.Энх-Амгалан)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (З.Ууганжаргал)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  П.ЧИНБАТ